ASIAN HEALTH SERVICES

Өөрийгөө болон гэр бүлээ хамгаалж өнөөдөр Томуугийн вакцин ( Flu vaccine) хийлгээрэй! Томуугийн вирус тархахаас өмнө эрт хийлгэх нь илүү сайн бөгөөд таныг энэ вирусаар хүндээр өвчлөх, эмнэлэгт хэвтэхээс урьдчилан сэргийлнэ. Томуугийн вакцин ( Flu vaccine) нь томуугаар өвчлөх шалтгаан биш.

**Олон газруудад Томуугийн вакцин ( Flu vaccine) хийж байна:**

1. **Олон эмийн сан ба дэлгүүрүүд, тухайлбал Walgreen's, CVS, Lucky's, Target, Safeway урьдчилан цаг товлох шаардлагагүй.** Та Томуугийн Вакцины Мэдээлэлийн Хүснэгт (Flu Vaccine Information Sheet) –ээ үзүүлэхэд л тэд ямар вакцин хийлгэхийг хүсч байгааг мэднэ. Иргэний үнэмлэх (ID card), эрүүл мэндийн даатгалын кардаа авч очоорой. Утасдаад вакцин байгаа, таны нас, эрүүл мэндийн даатгалыг хүлээн авах эсэхийг лавлаарай.
2. **Азийн Эрүүл Мэндийн Үйлчилгээний (АЭМҮ) Томуу Вакцины Эмнэлэг**
   - 12/05/2020 -Хүүхэд ба Насанд Хүрэгч, 818 Webster Street, Oakland, өглөө 9-өөс өдөр 1 цаг хүртэл
     6 сартайгаас 18 нас хүртэлх хүмүүс эцэг эх/хууль ёсны асран хамгаалагчтайгаа хамт байх **ёстой**. Хүүхдийнхээ АЭМҮ-ний кард(хэрэв үзүүлдэг бол), эрүүл мэндийн даатгалын кардыг авчраарай.
   - 12/12/2020 – Насанд Хүрэгч, 835 Webster Street, Oakland, өглөө 9-өөс өдөр 1 цаг хүртэл
3. **Аламеда Дүүргийн Олон Нийтийн Эрүүл Мэнд Томуу Вакцины Эмнэлэгүүд**
   - Аламеда Дүүргийн Олон Нийтийн Эрүүл Мэндийн цахим хуудас ( https://acphd.org/flu/flu-clinics/ ) –аар орж шинэчлэгдсэн мэдээлэл аваарай.